

АГУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт	3
1.2. Ордын талбай орчмын судлагдсан байдал	4
1.3. Ордын гидрогеологийн нөхцөл	6
БҮЛЭГ 2. ОРДЫН НӨӨЦ	7
2.1. Ордын өнөөгийн байдал	7
БҮЛЭГ 3. ДАЛД УУРХАЙН ТӨЛӨВЛӨЛТ	8
3.1 Уулын ажлын горим	8
3.2. Далд уурхайн жонш олборлолтын календарьчилсан төлөвлөлт	8
3.2.1. Бэхэлгээний материалын зарцуулалтын тооцоо	8
3.2.2. Уулын малталтын нэвтрэлтийн өрөмдлөг тэсэлгээний ажил	9
3.3. Уулын малталт нэвтрэлтийн ухаж ачих болон тээвэрлэлтийн ажил	9
БҮЛЭГ 4. БАЯЖУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИ	10
4.1 Хүдэр баяжуулах технологийн туршилт судалгаа	10
4.2. Баяжуулах технологийн шийдэл	10
1.8. Дэд бүтэц	10
2.0. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	12
3.0. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	13
4.0. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
5.0. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
6.0. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨР	19
7.0. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
8.0. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
9.0. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
10.0. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
11.0. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
12.0. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	25
13.0. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	27
14.0. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сум багын иргэдэд тайлагнах ажлын хуваарь	28

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Хайлуур жоншны хүдрийн нөөц	7
Хүснэгт 2. Ажиллах горим	8
Хүснэгт 3. Бэхэлгээний материалын зарцуулалтын тооцоо	9
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах ажил	19
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26


Хүснэгт 9. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	27
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	28
Хүснэгт 11. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	29
Зургийн жагсаалт	
Зураг 1. талбайн байршлын тойм зураг.....	3

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт

“Өмнө бага чулуу” хайлуур жоншны орд нь засаг захиргааны нэгжийн хувьд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 450 км, Алтанширээ сумаас зүүн хойш 30 км-т, Бага чулуу уулын орчимд Улаанбаатар Сайншандын чиглэлийн хатуу хучилттай замын зүүн талд байрлана. Талбай нь номенклатурын хувьд L-49-078 нэрлэвэрт байрладаг

- Талбайн нэр: “Өмнө бага чулуу”
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн дугаар: MV-021637
- Ашиглалтын талбайн хэмжээ: 219.4 га



Зураг 1. талбайн байршлын тойм зураг

“Өмнө бага чулуу” ордын урд хүдрийн биетэд В зэрэглэлийн 4 ширхэг блок, С зэрэглэлийн 3 ширхэг блок, нийт 7 блок дээр нөөц тогтоосон байна. Геологийн нөөцийг бодитой В зэрэглэлээр 101,703.56 тн хүдрийн нөөц (дундаж агуулга 40.6% CaF_2), боломжтой С зэрэглэлээр 48,173.60 тн хүдрийн нөөц (дундаж агуулга 42.85% CaF_2) буюу нийт В+С зэрэглэлээр 149,877.17 тн хүдрийн нөөц (дундаж агуулга 41.32% CaF_2) байна. Орд нь бялхмал чулуулагт агуулагдах судлын төрлийн орд бөгөөд хүдэржилтийн итгэлцүүр, хүдрийн биетийн нийлмэл байдлын итгэлцүүр, хүдрийн биетийн зузааны болон агуулгын вариацийн итгэлцүүр зэргийг тооцсоноор Өмнө бага чулуу хайлуур жоншны ордыг II бүлгийн ордод хамааруулсан байна.

1.2. Ордын талбай орчмын судлагдсан байдал

Сэдэвчилсэн судалгаа: 1965 онд А.А.Храпов нар Дундговь, Дорноговь аймгийн нутагт 1:500 000-ны масштабын геологийн зураглалын ажлыг L-49-73-аас L-49-78; L-49-85-90, L-49-101, L-49-102 зэрэг хавтгайн хэмжээнд хийж, 500 т/км эрлийн маршрут, 45 сорьцлолтын ажил хийсэн. Судалгааны үр дүнд Хойд говийн бүс нутгийн геологийн тогтоц нь нэлээд тодорчээ. Эхний үед кембрий, ордовикийн метаморф чулуулаг тогтоосон бөгөөд Хар-Айраг формацийн тархалтыг илүү нарийвчлан тодорхойлсон. Талбайгаас цуглуулсан геологийн шинэ өгөгдлүүд нь энэхүү нутагт тархан байршсан магмын чулуулгийн тогтоц, тархалтыг тоймлон, шийдвэрлэхэд дөхөм болсон байна. Мөн энэхүү бүс нутагт тохиолддог протерозой, түрүү палеозойн магмын чулуулгийн тархалт, тогтцыг анхлан тоймлож өгсөн. Мезозойн магмын чулуулаг нь бүс нутагт хязгаарлагдмал тархалттай юм. Бүс нутгийн геологийн хөгжилд хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн томоохон тасралтат хагарлыг зохиогчид тогтоосон байна. Районд ашигт малтмалын флюорит, фосфор, зэс, алт, вольфрам, молибден, цагаан тугалга, хүрэн нүүрсний орд илрэлүүдийг тогтоосон. Мөн хайлуур жонш, зэс, алт, гянтболд, молибден, цагаан тугалга, хүрэн нүүрсний орд илрэлүүдийн хувьд сонирхолтой гэж тэмдэглээд, Улаан нуурын хүрэн нүүрсний геологийн нөөцийг 1.0 сая/тн-оор үнэлсэн байна. (ф1709) 1965 онд Чойрын геологи хайгуулын экспедицийн Алтанширээгийн 24 дүгээр ангийн геологич В.И.Васильев нар Дорноговь аймгийн Иххэт, Даланжаргалан, Айраг, Алтанширээ сумдыг хамарсан L-49-В хавтгайн зүүн хойд хэсэгт 1:500 000-ны масштабын гидрогеологийн зураглалын ажил хийж, гидрогеологийн нөхцөлөөр нь ус агуулагч 9 комплекс ялгаж, ургамлын үлдэгдэлд тулгуурлан пермийн хурдасны насыг шинэчлэн тогтоосон байна. Мөн ашигт малтмалын хувьд хайлуур жоншны хэд хэдэн илрэлийг тогтоож, Алтанширээгийн хайлуур жоншны ордын таамаг нөөцийг 100.0 мян/тн гэж үнэлгээ өгсөн байна. 10.0 мян/км² талбайд гидрогеологийн зураглал, 150 т/м шалгалтын маршрут 1506 т/м өрөмдлөг, 182 гидрохимийн дээж, 150 усны спектрийн дээж, 150 уран тодорхойлох усны сорьц, геофизикийн судалгаа, албадмал туйлшрал, 25 физик цэгт цахилгаан соронзон зэрэг ажлуудыг хийсэн. Судалгааны ажлын үр дүнд талбайн геологийн тогтоц архей, триасаас бусад бүх цаг үеийн, олон улсын стратиграфийн ангилалд багтдаг бараг бүх систем, үеийн төлөөлөл бүхий метаморф, тунамал, вулканоген, магмын чулуулгаас бүрдсэнийг тогтоосон. Гидрогеологийн судалгааны явцад гидрогеологийн нөхцөл, геоморфологийн орчин зэргийг тодорхойлсон болно. Талбай хэмжээнд дээд цэрдийн Сайншанд формацийн чулуулаг усаар хамгийн их ханасан уст давхаргыг бүрдүүлдэг. Зураглалын ажлаар рашаан ус тогтоогдоогүй. Мөн энэ бүс нутагт 9 уст давхаргыг илрүүлсэн. Тус бүс нутагт ашигт малтмалын хэд хэдэн орд, илрэлийг тогтоосон. Үүнд: Алтанширээгийн флюоритын ордын нөөцийг 100 мян/тонн-оор баялгийн үнэлгээ өгчээ. Мөн судлаачид бүс нутгийн гүний усны үүслийн нөхцөл байдал, газар доорх усны нөөцийг цаашид судлах боломжтой гэж тодорхойлсон. 1966 онд Дорнодын геологи хайгуулын экспедицийн геологич

А.Ф.Кургузкин Г.Ф.Милин нар Хэнтий, Сүхбаатар, Дорноговь аймгийн нутагт хамарсан L-49-XV, XVI, XXI, XXII хавтгайн хэмжээнд 1:200000-ны масштабын геологийн зураглалын ажлыг гүйцэтгэж, 2500 км² талбайд зураглал, 309 м³ суваг малтаж, 6530 ширхэг металлометрийн дээжлэлт авч, 20 удаа гидрохимийн дээж хийж, 1020.0 т/км талбайд геофизикийн авто-гамма судалгаа хийж, 75 цэглэн сорьцлолтын ажлуудыг тус тус хийсэн байна. Үүний үр дүнд районы давхарга зүйг нарийвчилж, мезозойн интрузив чулуулгийг анхлан тогтоож, пермийн вулканоген-тунамал чулуулаг хожуу палеозойн гранитоид дээгүүр трансгрессив байдлаар хучиж тогтсоныг илрүүлсэн. Мөн хайлуур жонш, зэс, төмөр, шохойн чулуу, перлитийн орд болон гянт болд, зэс зэрэг бусад элементийн сарнимал хүрээнүүдийг илрүүлсэн байна. Гэтэн шанд флюоритын талбай дахь Адагбаянгийн флюоритийн илрэлийг хэтийн төлөвтэй хэмээн гэж үзэж, цаашдын судалгаанд хамруулахыг санал болгосон. Мөн хожуу палеозойн боржин чулуулаг, дунд юрагийн бялхмал чулуулгийн контактын бүсэд ажиглагдсан гянт болдын ореолыг шалгахыг зөвлөсөн байна. Түүнчлэн гидрогеологийн судалгааны мэдээлэлд тулгуурлан бүс нутгийн гүний усны ангиллыг хийж гүйцэтгэсэн байна.

1981-1983 онуудад Чойрын геологийн нэгдлийн геологич Д.Баадай Д.Эрдэнэбилэг нар Хэнтий, Дорноговь аймгийн Буянт, Дэлгэрэх, Их-Хэт сумдыг хамарсан Эрдэнэцогтын талбайд 1:50000-ны масштабын геологийн зураглалын ажил хийсэн. Тус ажлаар 1930 км² талбайд зураглал, 40 км² талбайд 1:10000-ны масштабтай эрлийн маршрут, 2074.5 м³ гар суваг, 10784 м³ суваг, 592 м³ шурф малталт, 1713 т/м цохилтот өрөмдлөг, 35270 ширхэг литогеохимийн дээжлэлт, 3396 шлихийн сорьцлолтын ажлуудыг тус тус хийсэн байна. Үүний үр дүнд Эрдэнэцогтын говийн депрессийн хэмжээнд доод цэрдийн нүүрс агуулагч хурдас тархсаныг тогтоож, мөн Оорцог-Овоо, Гэтэн шандын хайлуур жоншны 2 томоохон илрэлд эрэл-үнэлгээний ажил явуулж, жоншны нөөцийг Оорцог-Овоогийн илрэлд хайлуур жоншны 86.2% агуулгатай, P1-403.9 мянган тонн, Гэтэн шандын илрэл дээр хайлуур жоншны 45.2% агуулгатай, P1-98.3 мянган тонн баялгийг үнэлсэн байна. Түүнчлэн Үүдэнгийн ховор металл, Та-Nb эрдэсжилт, Си, Мо, Sn, Pb, Zn, Ag болон Bi-ийн литогеохимийн дээжийн үр дүнгээр томоохон гажлуудыг илрүүлсэн байна. (ф3748) 1986-1988 онуудад Сайншандын XI дүгээр ангийн геологич Г.Бөмбөрөө Ш.Лхүндэв Ж.Бүрэнтөгс нар Дорноговь болон Дундговь аймгийн нутагт агаарын зургийн тайлал ашиглан 1:200000-ны масштабтай геологийн бүлэгчилсэн зураглалын ажил гүйцэтгэсний үр дүнд эдгээр нутгийн геологи, тектоникийн тогтоц болон ашигт малтмалын талаарх шинэ мэдээллийг нэмж бүрдүүлсэн. Судлаачид зураглалын явцад карбоны Гүнбаянгаас бусад давхаргадас (формац)-ыг талбайн хэмжээнд шинээр ангилан зураглаж, доод-дунд рифейн хувирмал бүрдлийг доод анх төрмөлд хамааруулж, доод силюрын Оноо толгой, Мандал-Овоо, Номгон, Манхан уул, Хөх өндөр уул зэрэг давхаргадсыг шинээр ялгасан.

Түүнчлэн зохиогчид эртний өргөгдлийн бүс дэх эх газрын бялхмал чулуулагтай нягт эвшилдсэн рифей, перми, юра, цэрдийн структур болон Монголын их хагарлыг дагуух рифтоген бүтцийн бялхмал-шохойлог хурдастай эвшилдсэн венд-түрүү кембрийн субвулкан шургамал бүрдлийг шинээр ялгасан. Түрүү мезозойн /дунд төрмөл/-ийн боржинлог нь ховор болон газрын ховор төмөрлөгийн хүдэржилт, харин хожуу мезозой /дунд төрмөл/-н насны боржинлог нь хайлуур жоншны хүдэржилттэй болохыг тус тус тогтоожээ. Ашигт малтмалын хувьд Эрдэнэцогт уулын хүрэн нүүрсийг 904.2 сая.тн таамаг нөөцийг баялгийн хэмжээнд үнэлсэн бөгөөд түүнчлэн уг нүүрсний илрэлтэй уялдаатай үүссэн эрдсийн будгийн хуримтлалыг олж тогтоосон. Чандмань уулын хүдрийн талбайд P2 зэрэглэлээр 2.6 сая.тн нөөцтэй скарнойд төрлийн зэс-холимог төмөрлөгийн хүдрийн шинэ илрэл, зэс, цайрын

стратиформын төрлийн илрэл мөн цеолит, цагаан тугалга, цайр, бал чулуу, хайлуур жонш, гянтболдын илрэлийг шинээр тогтоосон. Зохиогчид нь цаашдын судалгаанд флорын үлдэгдэл агуулж буй давхаргадсуудыг нарийвчлан шинжлэх, мөн талбайн хэмжээнд тогтоогдоод буй олон тооны илрэлд эрлийн ажлыг үргэлжлүүлэн явуулахыг зөвлөсөн байна. 2005-2007 онд Б.Дэлгэрцогт, Я.Дагва-Очир, Е.Мөнхбат нар Дорноговь Дундговь аймгийн төв болон хойд хэсгийг хамруулан 1:200 000 масштабын геологи, ашигт малтмал, дөрөвдөгчийн геологи, экологи-геологийн иж бүрэн зургийг зохиосон бөгөөд энэхүү ажлын талбайд манай ордын район багтаж байгаа юм.

Эрлийн ажил: 1976-1977 онуудад Геофизик-топо зургийн экспедицийн О.И.Бондаренко Л.Маргай, Т.Сэнгэдорж нар Төв Монголын L-48-XXXI, L-48-XXIV, Дорноговь аймгийн Дэлгэрэхийн талбайн L-49-XXI хавтгайд эрэл-шалгалтын ажлын хийсэн. Эрэлшалгалтын ажлыг Дэлгэрэх, Дундговь, Хараа гол болон Баянлиг гэсэн 4 дүүрэгт хийж, Арс худаг, Хар-Чулуут, Төмөртэй, Хонгор-овоо, Баруун-Чойр, Хэсэр-Худаг, Нүхт, БаруунХараа, Хараа гол, Зургаан-Худгийн нуруу, Өмнө Бага чулуу гэх мэтийн гянтболд, цагаан тугалга, алт, хайлуур жонш, мөнгөн усны хүдэржилт бүхий 20 талбайд гүйцэтгэжээ. Эдгээр талбайг өмнөх судлаачдын судалгааны ажил дээр үндэслэсэн ба мөн хүдэржилтийн шууд шинж тэмдэг шлих, металлометрийн сарнилын хүрээ, хувирал зэрэг шинж тэмдгийг харгалзан үзсэн байдаг. Судалгааны талбайн хэмжээнд эрлийн маршрут, 3410 шлихийн дээжлэлт, 1002 м3 суваг, 425 м3 шурф малталт, 5094 металлометрийн дээжлэлт, 3210 минералогийн шинжилгээ хийсэн байна. Ажлын үр дүнд, Хар-Чулуу, Арс худгийн гянтболдын илрэл, Хараа голын дүүрэгт киноварийн 2 илрэл, Чандмань-Уулын зэс-төмрийн хүдрийн орд, хэд хэдэн алтны хоёрдогч сарнилын хүрээ, Төмөртэй, ХонгорОвоо, Хараат-Уулын скарн-төмрийн хүдрийн ордын хэмжээнд шеелитийн эрдэсжилт зэргийг шинээр тогтоосон байдаг. Мөн түүнчлэн зохиогчид, шинээр тогтоогдсон илрэл, эрдэсжилтийн хэмжээнд цаашид хийгдэх ажил болон ховор металлын эрэл-шалгалтын ажил явуулах хэрэгтэй талбай зэргийг зөвлөмж болгожээ. (ф2315) 1989-1992 онуудад Чойрын геологийн нэгдлийн "Говь-гео" ХК-ны геологич П.Ганбаатар А.Батхүү нар Дорноговь аймгийн Алтанширээ, Дэлгэрэх сумдын нутагт, L-49-78, 79, 89, 90 байр зүйн зургийн хавтгайнуудын зарим хэсэгт 1:50000 масштабтай геологийн зураглалын ажлыг хийсэн. Геологийн зураглал, ерөнхий эрэл, гидрогеологийн тойм судалгаа, геофизикийн судалгаа, шлих, геохимийн сорьцлолт, уулын ажил хийсний үндсэн дээр баримт материал, геологи, ашигт малтмал, геоморфологи, эрлийн талбайн геологийн зургуудыг 1:200 000, 1:50 000 1:25 000 болон 1:10 000 масштабтайгаар зохиож, давхарга зүйн эрэмбээр 7 насны хурдас чулуулаг ялгаж, 8 насны гүний болон субвулкан чулуулаг тэдгээрийн фаз, хил заагийн өөрчлөлтүүдийг судалсан байдаг.

1.3. Ордын гидрогеологийн нөхцөл

“Өмнө бага чулуу” хайлуур жоншны ордын урд хүдрийн биетийн баруун үргэлжлэлийн талбайд гидрогеологийн давхарга зүйн ангиллын дагуу газар доорх усны байрлал, хөдөлгөөн, хуримтлагдах нөхцөл, геологи-литологийн бүтэц, тогтоц зэргийг харгалзан бялхмал-тунамал гаралтай чулуулгийн ан цавын усажсан бүсийн алаг цоог тархалттай газрын доорх ус тархсан байна. Ордын талбайд 38.0 м-ийн гүнээс газрын доорх ус илэрсэн карьерт шүүрэх усыг 2 аргаар тооцов. Ил малталтад орж ирэх усны хэмжээг “Их худгийн” томъёогоор тодорхойлоход 6.9 л/с тооцогдсон байна. Бялхмал-тунамал чулуулгийн ан цавын сүлжээний тархалт нь гүний бүтэц болон талбайн хэмжээнд харилцан адилгүй жигд бус байдагтай холбоотойгоор ан цавын бүсэд агуулагдаж буй газар доорх ус нь нөөц баялгийн хувьд хязгаарлагдмал, алаг цоог тархалттай байна. Ордын газар доорх усны үндсэн нөөц, баялгийг бүрдүүлэгч өгөршилан

цавын усажсан бүсийн алаг цоог тархалттай газар доорх ус нь алсын тэжээгдэлгүй, харьцангуй усжилт багатай харагдах ч тектоник хагарлын бүсэд ан цавын харьцангуй өндөр усжилттай газар доорх усны голомт байж болохыг олборлолтын явцад анхаарах шаардлагатай. “Өмнө бага чулуу” хайлуур жоншны ордын урд хүдрийн биетийн баруун үргэлжлэлийн талбай дахь 1.3 л/с ундаргатай /хээрийн хэмжилтийн үед/ устай худагт бид засвар үйлчилгээ хийн орон нутгийн иргэдэд хүлээлгэн өгсөн бөгөөд цаашид бид энэ худгийн усыг ашиглах талаар хариуцсан байгууллагад хандаад байна.

БҮЛЭГ 2. ОРДЫН НӨӨЦ

“Өмнө бага чулуу” ордын урд хүдрийн биетэд В зэрэглэлийн 4 ширхэг блок, С зэрэглэлийн 3 ширхэг блок, нийт 7 блок дээр нөөц тогтоосон байна. Геологийн нөөцийг бодитой В зэрэглэлээр 101,703.56 тн хүдрийн нөөц (дундаж агуулга 40.6% CaF₂), боломжтой С зэрэглэлээр 48,173.60 тн хүдрийн нөөц (дундаж агуулга 42.85% CaF₂) буюу нийт В+С зэрэглэлээр 149,877.17 тн хүдрийн нөөц (дундаж агуулга 41.32% CaF₂) байна. Орд нь бялхмал чулуулагт агуулагдах судлын төрлийн орд бөгөөд хүдэржилтийн итгэлцүүр, хүдрийн биетийн нийлмэл байдлын итгэлцүүр, хүдрийн биетийн зузааны болон агуулгын вариацийн итгэлцүүр зэргийг тооцсоноор Өмнө бага чулуу хайлуур жоншны ордыг II бүлгийн ордод хамааруулсан байна.

2.1. Ордын өнөөгийн байдал

Ордын одоогийн бодит байдлын хувьд хууль бус олборлогчид нэвтэрч хүдрийн биетийн суналын дагуу С-7 блокоос В-3 блок хооронд гарш хэсгээс доош хамгийн гүндээ 6 м хүртэл уурхайн карьер үүсгэсэн байгаа. Хууль бус олборлогчид ордын В-3, В-4, С-7 гэсэн блокуудаас нийт 427.6 тонн жоншны хүдэр олборлосон байна. Энэхүү үүссэн уурхайн маркшейдерийн хэмжилтийг 2022 оны 03 дугаар сард “Эн Эс Эй” ХХК гүйцэтгэсэн. Хэмжилтийн ажлын суурин боловсруулалт хийхэд:

- Бодитой В-3 нөөцийн блокоос 82.3 тн хайлуур жоншны хүдрийн нөөц,
- Бодитой В-4 нөөцийн блокоос 140.4 тн хайлуур жоншны хүдрийн нөөц,
- Боломжтой С-7 нөөцийн блокоос 204.9 тн хайлуур жоншны хүдрийн нөөц тус тус хууль бус олборлолтод өртсөн байна.

Хүснэгт 1. Хайлуур жоншны хүдрийн нөөц

№	Блокийн дугаар	Блокийн талбай S /м2/	Хүдрийн биетийн дундаж зузаан m / м /	Блокийн эзлэхүүн V /м3/	Хувийн жин т/м3	Хүдрийн хэмжээ Q /тн/	Дундаж агуулга C / % / CaF ₂	Хайлуур жоншны нөөц P /тн/
1	В-1	4807.57	1.73	8308.99	2.67	22184.99	43.31	9609.26
2	В-2	4284.20	2.24	9611.83	2.67	25663.58	41.53	10659.26
3	В-3	4351.83	2.46	10699.30	2.67	28567.12	38.73	11065.02
4	В-4	4675.69	2.03	9471.11	2.67	25287.87	39.38	9959.22
5	С-5	3969.57	1.81	7197.26	2.67	19216.68	45.33	8711.10
6	С-6	4124.78	1.82	7527.24	2.67	20097.73	40.28	8096.10
7	С-7	1763.00	1.88	3318.05	2.67	8859.19	43.30	3836.30
В зэрэглэлээр	18,119.29	2.10	38,091.22	2.67	101,703.56	40.60	41,292.77	
С зэрэглэлээр	9,857.35	1.83	18,042.55	2.67	48,173.60	42.85	20,643.49	
В+С зэрэглэлээр	27,976.65	2.01	56,133.77	2.67	149,877.17	41.32	61,936.26	

БҮЛЭГ 3. ДАЛД УУРХАЙН ТӨЛӨВЛӨЛТ

3.1 Уулын ажлын горим

Далд уурхайн үйл ажиллагаа нь жилийн турш тасралтгүй ажиллана. Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цагаар ажиллана. Дараах хүснэгтэд уурхайн ажиллах горим, ээлжийн зохион байгуулалтыг харуулав.

Хүснэгт 2. Ажиллах горим

	Үзүүлэлт	
Хуанлийн хоног	365	өдөр
Баяр ёслол тооцсон хоног	7	өдөр
Цаг агаарын хүнд нөхцөл тооцсон хоног	5	өдөр
Жилийн ажлын өдөр	270	өдөр
Ээлжийн үргэлжлэх хугацаа	12	цаг
Хоногт ажиллах ээлжийн тоо	2	ээлж
Ээлжийн цаг ашиглалт		
Ажлын наряд авах цаг	20	мин
Хоолны цаг	60	мин
Ээлж хүлээлцэх хугацаа	20	мин
Бусад	10	мин
Ээлжин дэх сул зогсолт	110	мин
Ээлжийн үргэлжлэх хугацаа	12	цаг
Ээлжийн цэвэр ажиллах цаг	10.2	цаг
Ээлжийн цаг ашиглалт	85%	

3.2. Далд уурхайн жонш олборлолтын календарьчилсан төлөвлөлт

Далд уурхайгаар олборлох нийт нөөцийн хэмжээ 81.14 мян.тн, далд уурхайн жилийн хүчин чадал 45.0 мян.тн бөгөөд далд уурхайн ашиглалтын хугацаа 2 жил байна. 2023 оны уулын ажлаар нээгч үндсэн малталт болон бэлтгэл малталтыг нэвтэрсэн бөгөөд 2024 онд үлдсэн нэвтрэлтийн ажлыг дуусгаж хүдэр олборлох ажлыг эхлүүлсэн байна. Харин 2025 оны уулын ажлаар +1086-1126м-ийн түвшинд олборлолт хийхээр төлөвлөв. Уулын ажлаар 43.34 мян.тн хайлуур жоншны хүдэр олборлохоор байна.

3.2.1. Бэхэлгээний материалын зарцуулалтын тооцоо

Төмөр бетон бэхэлгээ. Уурхайн босоо далд уурхайн ерөнхий гарц тул босоо амыг төмөр бетон бэхэлгээгээр бэхлэхээр тооцсон. Босоо амны нийт гүн 115 м ба босоо амны ёроолд ус хуримтлуулах зумпыг байгуулна. Босоо амыг бүхэлд нь төмөр бетон бэхэлгээгээр бэхлэхээр тооцсон. Төмөр бетон бэхэлгээнд 100, 150, 200 маркийн бетон хэрэглэнэ.

Набрызг бетон бэхэлгээ. Набрызг бетон бэхэлгээ буюу шүршмэл /торкрет/ бетон бэхэлгээг их ам орчмын малталт, квершлаг малталтын хана таазанд шүршинэ. Шүршмэл бетон бэхэлгээ бэхлэх нийт урт 284 м байна. Шүршмэл бетон бэхэлгээг хийхдээ бетон зуурмагийг тусгай зориулалтын бетон зуурагч шүршигч машинаар малталтын хана таазанд шүршинэ. Шүршсэн бетоныг хурдан хатааж хатууруулахын тулд хлорт кальци болон фторт натрийг нэмэлт хольц болгон хэрэглэж болдог.

Модон бэхэлгээ Штрек восстающий малталтуудыг модон болон модон раман бэхэлгээгээр бэхэлж рам хоорондох чигжээс болон тавцанд банз ашиглана.

Хүснэгт 3. Бэхэлгээний материалын зарцуулалтын тооцоо

№	Бэхэлгээний төрөл	Бэхэлгээний үндсэн материал	Нэгж	1 м малталтад ногдох материалын зарцуулалт
1	Бетон	Бетон зуурмаг	м³	2.24
	Арматур	тн	0.1	
	Төмөр утас	м	11.0	
2	Набризг бетон	Бетон зуурмаг	м³	0.41
3	Набризг бетон	Бетон зуурмаг	м³	0.41
4	Модон раман бэхэлгээ	Модон рам	м³	0.29
	Бэхэлгээний банз	м³	0.29	
5	Модон раман бэхэлгээ	Модон рам	м³	0.29
	Бэхэлгээний банз	м³	0.29	
6	Модон бэхэлгээ	Модон рам	м³	0.18

3.2.2. Уулын малталтын нэвтрэлтийн өрөмдлөг тэсэлгээний ажил

Уулын малталт нэвтрэлтийн ажилд өрөмдлөг хийх үед 42 мм диаметр бүхий БНХАУ-д үйлдвэрлэгдсэн доорх төрлийн гар перфоратор ашиглана. Шпуруудыг цөмлөх, нураах, хэв гаргах зориулалтаар мөргөцөгт хуваарилан байршуулна. Чулуулгийг тэслэх ажилд бортоготой тэсрэх бодис хэрэглэнэ. Цаасан бортоготой тэсрэх бодисын диаметр нь 32 мм, урт нь 0.24 м, масс нь 0.25 кг байна.

Гар перфераторыг БНХАУ-д үйлдвэрлэсэн гар перфераторуудаас техникийн үзүүлэлт, бүтээл, үнэ зэргээс хамааруулж YT-28 маркийн гар перфераторыг сонгосон.

3.3. Уулын малталт нэвтрэлтийн ухаж ачих болон тээвэрлэлтийн ажил

Уурхайн босоо малталт нэвтрэлтийн ажилд чулуулаг ачиж, тээвэрлэхэд 0.8 м³ багтаамж бүхий нэвтрэлтийн хөнөгөөр тоноглогдсон нэвтрэлтийн тавцан ашиглана. Уурхайн босоо малталт нэвтрэлтийн ажилд чулуулаг ачихад КС-2У/40 төрлийн 0.65 м³ утгуурын багтаамж бүхий грейфер, тээвэрлэхэд БПС-1/1150 төрлийн 1 м³ багтаамж бүхий нэвтрэлтийн хөнөгөөр тоноглогдсон нэвтрэлтийн тавцан ашиглана. Грейферийн цагийн бүтээл 28.2 м³/цаг байна. Грейфер болон нэвтрэлтийн хөнөгийн техникийн үзүүлэлтийг доор хүснэгтэд үзүүлэв.

Өргөх хэсгийн жилийн бүтээл 86.1 мян.тн байгаа ба босоо амаар жилд гарах нийт уулын цулын хэмжээ 43.28 мян.тн байгаа нь өргөх машины бүтээл уурхайн хүчин чадлыг бүрэн хангаж ажиллахаар байна.

Хэвтээ малталт нэвтрэх үеийн ачих, тээвэрлэх. Нураагдсан хүдэр болон хоосон чулууг ачих ажилд ZWT-60A маркийн 0.1 м³ утгуурын багтаамжтай ачигч машин, YA-26 маркийн 0.8 м³ тэвшний багтаамж бүхий өөрөө буулгагч 3 дугуйт тээврийн машин ашиглана. ZWT-60A маркийн ачигч машины тодорхойлолтыг дараах хүснэгтэд үзүүлэв.

БҮЛЭГ 4. БАЯЖУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИ

“Өмнө бага чулуу” хайлуур жоншны ордын дээжид технологийн туршилтын ажлыг “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-д 2020 онд хийлгэсэн. Технологийн туршилтаар анхдагч дээжинд хийсэн химийн шинжилгээгээр CaF_2 -38.10%, CaCO_3 -0.82%, SiO_2 - 55.19%, $\Sigma S < 0.10$, P-61.92 мг/кг тус тус агуулгатай, 216 кг жинтэй дээжид хийж гүйцэтгэсэн байна.

4.1 Хүдэр баяжуулах технологийн туршилт судалгаа

Баяжуулах технологийн туршилтыг нийт 216 кг дээжинд дараах туршилт шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Анхдагч дээжийн шинжилгээ
- Дээж бэлтгэл
- Сорьцлолтын ажил
- Минералогийн шинжилгээ
- Шигшүүрийн шинжилгээ
- Бүхэл жонш ялгах туршилт
- Нунтаглалтын горим тогтоох
- Урвалжийн зарцуулалт тогтоох
- Флотацийн аргаар баяжуулах туршилт хийсэн.

Туршилт шинжилгээний ажлуудыг гүйцэтгэн үндсэн флотаци, хяналтын 1 шатны флотаци, цэвэрлэгээний 5 шатны битүү циклийн флотациар баяжуулж 95.0% агуулгатай, 98.07% эрдэс авалттай баяжмал гарган авах боломжтой гэж тогтоосон байна.

Бүхэл жонш ялгах туршилт “Мандах дорнын жонш” ХХК-аас нэмэлт дээжийг “Геологийн Төв Лаборатори” ТӨҮГ-д хүргүүлэн бүхэл жонш ялгах туршилт хийлгэсэн байна. Тус туршилтад CaF_2 -52.1% агуулгатай дээжинд ялгалт хийж бүхэл жонш нь 85.19% агуулгатай, 13.07% гарцтай байсан байна. Тус бүхэллэг жонш нь MNS 0145:2016 “Хайлуур жонш. Марк ба техникийн шаардлага” стандартын МБФ 85 маркийн металлургийн зориулалтын бүхэллэг хайлуур жоншны стандартын шаардлагад нийцэж байна.

4.2. Баяжуулах технологийн шийдэл

Далд уурхайн төлөвлөлтөөр ордоос 40.74% агуулгатай 43.34 мян.тн хүдрийг 2025 онд олборлоно. Олборлосон хүдрийг хэрхэн боловсруулах, баяжуулах талаар технологийн туршилтыг үндэслэн тооцож дараах шийдэл хүрэв.

1. Флотацийн аргаар баяжуулах туршилтыг үндэслэн хүдэр баяжуулах үйлдвэр байгуулахаар тооцож үзэхэд төсөл хэрэгжих хугацаа болон ордын нөөцөөс шалтгаалж эдийн засгийн ямар ч ашиггүй болох нь харагдаж байна.
2. Ордын дундаж агуулга нь бүхэл жонш ялгах туршилтад орсон дээжийн агуулгаас 14%-иар бага байна. Агуулга буурснаар дагаад технологийн үр дүнгүүд буурдаг. Ордын хүдрийн дундаж агуулгаас хамааруулан баяжуулалтын бүтээгдэхүүний гарц тодорхойлоход 7.3% гарцтай, 85% агуулга бүхий бүхэллэг жонш гарган авна. Гар аргаар ялгах нь хамгийн зардал багатай технологи боловч эдийн засаг талаасаа үр ашиггүй байна. Технологийн туршилтын үр дүнгээс харахад флотацийн аргаар баяжуулах нь тохиромжтой хэдий ч орд ашиглалтын хугацаа, ордын нийт нөөцөөс шалтгаалж төсөл хэрэгжүүлэгч талд олборлосон жоншны хүдрийг уурхайгаас 3 км зайд байрлах хүдэр баяжуулах үйлдвэрт нийлүүлэхээр төлөвлөв.

1.8. Дэд бүтэц

Өмнө бага чулуу хайлуур жоншны орд нь засаг захиргааны нэгжийн хувьд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 450 км, Алтанширээ

сумаас зүүн хойш 30 км, Иххэт-Алтанширээ чиглэлийн сум хоорондын замаас зүүн тийш 15 км зайтай оршдог.

Усан хангамж

Ундны ус. Уурхайн ажилчдын ундны усны хэрэглээг БОНХАЖСайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” А/301-р тушаалын 12-р хавсралт “Төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын системд холбогдоогүй орон сууц”-д 1 хүн 50 л/хон гэсэн нормыг баримталж ундны ус хэрэглээний тооцоог хийж дараах хүснэгтэд үзүүлэв. Уурхайнд 59 хүн байрлаж ажиллана.

Уурхайн цахилгаан хангамж

“Өмнө бага чулуу” хайлуур жоншны ордоос баруун тийш 20 км зайд Иххэт сумаас Алтанширээ сум хүртэл татсан 35 кВ-н өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам өнгөрдөг. Ил уурхайд ажиллах үндсэн техникууд нь өөрөө явагч байх тул дэд бүтцийн цахилгаан ачааллын тооцоо болон техникийн даалгаврыг үндэслэн дизель генераторын тусламжтайгаар ордын цахилгаан хангамжийг хангахаар тооцлоо. Ил уурхайн цахилгаан эрчим хүчний гол хэрэглэгчид нь:

Ил уурхайн цахилгаан хэрэглэгчид Уурхайн хотхоны хэрэглэгчид Засварын газрын хэрэглэгчид Ус хангамжийн хэрэглэгчид дээрх цахилгаан хэрэглэгчид бүгд 0.4 кВ–ын цахилгаан хүчдэлээр ажиллана. Өмнө бага чулуу хайлуур жоншны ордын цахилгаан эрчим хүчийг шаардлагатай 100 кВА чадалтай дизель генераторыг угсран уурхайг цахилгаанаар хангана.

Дулаан хангамж

Уурхайн ажилчдын гэрийг галлагаагаар халааж, уурхайн захиргаа болон гал тогоо, засварын газрын барилга байгууламжуудын халаалтыг нам даралтын зуухаар халаахаар төлөвлөсөн. Уурхайн оффисын байр, гал тогоо, амралтын байр зэрэг уурхайн халаалт шаардлагатай бүхий л хэрэглэгчдийг хүйтний улиралд халааж дулааны улиралд халаалтыг зогсоохоор төсөлд тусгаж өгсөн.

Уурхайн барилга байгууламж

Уурхайн бэлтгэл ажлын хүрээнд уурхайн барилга байгууламжийг барих бөгөөд уурхайн хотхонд дунджаар 60 хүн амьдрах ажилчдын амрах байр, хотхоны гал тогоо, халуун ус, спорт талбай, машины зогсоол, граж, агуулах зэргийг барихаар төлөвлөсөн. Тосгоны барилга байгууламжийг сэндвичин хавтант угсармал болон агуулах, складыг контейнероор хийхээр төсөлд тусгаж өглөө. Төслийн талбайн дэд бүтцийн хүрээнд дараах барилга байгууламжийг байгуулан ашиглалтад оруулж улсын комиссоор оруулан ашиглана. Үүнд:

- Ажиллах хүчний орон сууц, үйлчилгээний байгууламж
- Захиргаа
- Засварын газар
- Тээврийн зам
- Тэсрэх материалын агуулах
- Шатахуун түгээх станц
- Бусад инженерингийн байгууламжуудыг байгуулна.

Уухайн хотхон: Уурхайн хотхоныг ордын баруун зүгт 800 м зайтай байгуулна. Хотхон нь ажилчдын амьдрах гэр, захиргааны байр, ажилчдын цайны газрын байр болон угаалгын

газраас бүрдэнэ. Уурхайн ажиллагсдыг ахуйн зориулалтаар бүрэн тоноглогдсон монгол гэрт байрлуулах бөгөөд 1 гэрт 5 хүн байрлана.

Сэлбэгийн агуулах: Сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн түр агуулахыг 40 тн-ийн багтаамжтай контейнер ашиглан байгуулна. Жижиг эд анги хэрэгслийн хэмжээнээс хамаарч 2 ширхэг контейнер суурилуулна. Энд гар ажиллагаатай 3-5 тн-ийн даацтай тельеферээр тоноглогдсон байна.

ШТМ-ын агуулах: Шатах тослох материалын агуулах нь торон хашаагаар хүрээлэгдсэн задгай талбайд үйлдвэрлэлийн цогцолбороос 150 метрээс доошгүй зайд байрлана. Энд 100-200 литрийн багтаамжтай төмөр торхтой тосолгооны материал, масло болон уурхайн 7-10 хоногийн ажлыг хангах хэрэгцээний түлшний багтаамж бүхий ёмкость байрлана.

Тэсрэх материалын агуулах: ТМ-ын агуулахын тааз, хананаас бороо, цасны ус гоожиж нэвтрэхээс болгоомжлох ба агуулахыг тогтмол агааржуулж байх хэрэгтэй. ТМ-ыг агуулахад ачиж, буулгах үйлдлийг зөвхөн энэ ажилд зориулагдсан техник, өргөх байгууламжийн тусламжтайгаар гүйцэтгэнэ. Тэсрэх материалын агуулах нь нэг доор хамгийн ихдээ 10 тн тэсрэх бодис хадгалах боломжтой 20 тн багтаамжтай 1 ширхэг контейнер, тэсэлгээний хэрэгсэл хадгалах зориулалттай 20 тн багтаамжтай 1 ширхэг контейнер байх ба зориулалтын дагуу үл шатах материалаар доторлон ашиглана. Тэсрэх материалын агуулахын эргэн тойронд бусад объектууд байрлаж байгаа талд нь нарийн ширхэглэлтэй шороогоор хамгаалалтын далан байгуулна. Далангийн өндөр нь агуулахын өндрөөс 1 м-ээс багагүй өндөртэй байна. Мөн агуулахын агааржуулалтын системийг агаар чөлөөтэй сэлгэж байхаар бодож шийднэ.

Засвар механикийн цех. Орд газрыг ашиглаж үйлдвэрлэл явуулах явцад олон тооны том жижиг тоног төхөөрөмж, техник хэрэгсэл ашигладаг. Эдгээр техник тоног төхөөрөмжид ашиглалтын явцад эвдрэл гэмтэл гарах буюу элэгдэлд орно. Уг элэгдэл болон аливаа жижиг засвар үйлчилгээг хийх зорилготой үйл ажиллагаа явуулах газар нь засвар механикийн цех юм. Засвар механикийн цех нь технологийн үндсэн болон туслах тоног төхөөрөмжид их, дунд, урсгал засвар хийх, элэгдсэн эд ангийг сэргээн засварлах, эд ангиудын эвдрэл гэмтлийг засаж, сэлбэх, цахилгаан тоног төхөөрөмж засварлах зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ.

2.0. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүн ам, дэд бүтэц. Дорноговь аймаг нь 109.5 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй 14 сум, 65 багтай. Хэрэглээний бүсчлэлээр зүүн бүст хамаарна. Дорноговь аймаг Монгол орны зүүн өмнөд хязгаарт урд талаараа БНХАУ-тай хил 600 км-ээр хиллэдэг. Улс дотор Өмнөговь, Сүхбаатар, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий аймгуудтай хиллэдэг. Хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Аймгийн хэмжээнд нийт хүн амын тоо 71.0 мян орчим бөгөөд гол тэнхлэг замын дагуу тус аймгийн бүх сумын 42.8 хувь, хүн амын 61 хувь нь оршин сууж байна. Алтанширээ сум нь Улаанбаатар хотоос 450 км, аймгийн төвөөс зүүн хойш 90 км-т байрладаг. Цаг уурын эрс тэс уур амьсгалтай, 7200 км² газар нутагтай, говь хээрийн бүс нутагтай, баруун урд талаараа Сайншанд, Сайхандулаан, баруун талаараа Айраг, хойд талаараа Иххэт, Хэнтий аймгийн Галшар сум, зүүн, зүүн урд талаараа Дэлгэрэх, Өргөн сумдтай хил залган оршино. Алтанширээ суманд Тойг, Зараа, Хаяа, Чулуунгишгэр гэсэн 4 багийн нийт 1340 орчим хүн амьдардаг. Хүн амын тоогоор Дорноговь аймгийн 14 сумаас 13-т, газар нутгийн хэмжээгээр 9-д ордог. Хүн амын нягтрал 5.63 хүн/га/. Сумын төвийн нийт хүн амын 40 гаруй хувь нь сумын

төвд байрладаг. Сумын нийт хүн амын 58 орчим хувь нь залуу болон дунд насныхан, 30.5 хувь нь хүүхэд, 10 орчим хувь ахмадууд байна.

Газар зүй. Монгол орны металлогенийн орчин үеийн ангиллаар Дорнод Монголын флюоритжилтын бүслүүрийн Идэрмэгийн металлогений бүсийн Алтанширээгийн хүдрийн дүүрэгт хамаарагддаг. Хайгуулын талбай нь Төв Азийн геоморфологийн их мужийн Монголын Дорнод мужийн Дорноговийн дэд мужид хамаарна.

Цаг уур.

Судалгааны талбай нь жилийн дөрвөн улирал ээлжлэн солигддог эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын температурын зөрүү их. Өвөл нь -37.5C хэм хүртэл хүйтэрнэ. Зун хамгийн их халж +34.9-өөс +40C хэм хүрнэ. Жилд унах хур тунадасны хэмжээ дунджаар 277 мм бөгөөд үүний 70 гаруй хувь нь зуны улиралд бууна. Жил бүрийн 10-р сарын сүүл үеэс цас орж хүйтний улирал эхэлдэг. Салхины хурд 3-5 м/сек-ээс 18 м/сек хүрнэ. Заримдаа түүнээс ч хүчтэй шороон шуурга шуурна.

Хөрс ургамал. Тус сумын нутаг ботаник газар зүйн мужлалаар дээгүүр, Монголын хээрийн тойргийн Нялгын районд хамаарна. Уулын хээрт: Цахилдаг, алаг өвст, хиаг-хялганат, бужмаг, хонгорзул, улалж, бут бударгана, харгана, халгай, буурцагт өвсний төрөл зонхилно. Тал хээрт: Үетэн хялганат, хазаар өвс, хиаг-хялганат, шарилж, лууль, дэрс болон амт чанар, шимт сайтай үетэн, буурцагт, алаг өвсний төрлийн ургамал зонхилно. Мөн гол, булаг, нуур тойрмын хөвөөгөөр хиаг, хазаар өвс, салхин ерхөг, дэрс, харгана, адамын агь, хэрс зэрэг ургамал ургадаг ба сумын урд говирхог талаараа таана, мангир, хөмүүл, ерхөг, үетэн хялганат, алаг өвс, жижиг бутан үетэн, ботууль ургамал зонхилон ургадаг байна. Сумын нийт бэлчээрийн 4.5% нь цэвэр бэлчээр, 59% нь сөөгт бэлчээр, 22% нь чулуурхаг бэлчээр, 14.5% нь довонтой бэлчээр байна. Эмийн ургамлаас: Юлдэн тарваган шийр, өргөст сарнай, нохойн хошуу, говийн ганга, таван салаа, царван, хөх дэгд, шар дэгд, цөс өвс, арц, банздоо, бошго, сөд, соргол зэрэг олон зүйлийн эмийн ургамал ургадаг.

3.0. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ

Уурхайн үйл ажиллагаагаар 2025 онд 43.34 мян.тн хүдэр олборлолт явуулж газрын хэвлийд өөрчлөлт оруулна.

Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Ил уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэнэ. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй.

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

Байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж

Сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. Стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авах.
- Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах.
- Тоосжилт тархах хүрээ ачиж, тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчимд байхаар зам, овоолгын байршлыг оновчтой сонгох, улмаар байнгын ажлын байрнаас зайдуу байршуулах хэрэгтэй.
- Уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замуудыг байнга усалж байх, ялангуяа тоосжилт, шороон шуурганы гаралт нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд төслийн талбайг усаар норгох, чийглэх
- Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх.
- Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх.
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх
- Ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтсон нэг маршрутын дагуу явуулах, МУ-ын стандартын дагуу замын уулзвар, салаалалт дээр тэмдэгжүүлэх
- Үржил шимт өнгөн хөрсийг хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах
- Уурхайн үйл ажиллагааны явцад боломжтой газруудад нөхөн сэргээлтийг дор дор нь хийж байх
- Ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах
- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авах
- Тоног төхөөрөмжийн шатах тослох материал болон барилгын материалын Төвлөрсөн цэгийг байгуулж, нэвчүүлэхгүй материал ашиглан тохижуулах
- Шатах тослох материал, алдагдах, асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Уурхайн дотоод, гадаад тээврийн үйл ажиллагаанаас үүсэх орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг ашиглахаас аль болох зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах
- Тоосны ялгаралтыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгахын тулд байнгын хяналттай ажиллах зэрэг арга хэмжээг авч ажиллана.

4.0. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газар, БОАЖЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу “МАНДАХ ДОРНЫН ЖОНШ” ХХК-ийн “Өмнө бага чулуу” хайлуур жоншны далд ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Төсөл хэрэгжүүлэгч “МАНДАХ ДОРНЫН ЖОНШ” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагааны сөрөг нөлөөллөө байгальд үзүүлж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх ёстой.

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	9
1	Агаарын чанар Салхины хурд 10 м/с үед тээвэрлэлтийн замаас үүсэх тоосонцрын агууламж стандарт хэмжээнээс давж болзошгүй	Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх	Уурхайн бүх авто машинуудад	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	2025 он	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 - MNS 3384:82
		Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Уурхайн хэмжээнд	-	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон	2025 он	
		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	2025 он	
	Нийт	-					

2	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Аймагтайгаа ус ашиглах гэрээ байгуулж, сав газраар усны дүгнэлтээ гаргуулж, төлбөрөө төлнө.			Дотоод үйл ажиллагааны зардалд	2025 он	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008
		Хаягдал усны дүгнэлт гаргуулж сумтай гэрээ байгуулна.	-			2025 он	
		Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Зардал нь хяналт шинжилгээний зардалд орсон			2025 онд	
		Шүүрлийн усны шавхах хэсэг дээр тоолуур суурилуулна.	/тоолуурыг аймгийн хэмжил зүйн газраас авах/ Дотоод үйл ажиллагааны зардалд			2025 онд	
	Нийт	-					
3	Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	Газар эзэмших гэрээний дагуу төлбөрөө төлөх	Уурхайн хэмжээнд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	2025 он	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Машины зогсоол шинээр бий болгож, талбайг цементлэх	Машины зогсоол	-	500000	2025 он	
		ШТС-ын доод суурийг түлш, шатахуун асгарахаас сэргийлж суурийг цементлэх	ШТС-ын доод суурь хэсэгт		500000	2025 онд	
	Нийт	1000000					
4	Ургамлан нөмрөг болон Амьтны аймаг	Ургамлын зүйлийн бүрдлийн судалгаа	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	-	Орчны хяналт шинжилгээний зардалд	2025 онд 1 удаа	Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна.	Уурхайн хотхонд	-	7500000	2025 он	
	Нийт		750000				
5	Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 1750000						

5.0. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаагаар 2025 онд 43.34 мян.тн хүдэр олборлох ажил хийгдэх бөгөөд үүний улмаас уурхайн талбай болон түүнийг хүрээлэх байгаль орчинд зайлшгүй өөрчлөлт гарна. Үүсэж бий болсон сөрөг нөлөөллийг бууруулах болон арилгах арга хэмжээний үр дүн нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны чанарын түвшнээс ихээхэн хамаардаг. Уурхайн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэл бүхий зохион байгуулалт, техникийн арга хэмжээнүүдийн цогц бүрдэл байх бөгөөд эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр тухайн уулын үйлдвэр, түүний эргэн тойрон дахь бүс нутагт уулын ажлын явцад экологийн зөвшөөрөгдөх норм, норматив хангагдаж байх ёстой. 2025 онд өмнө ил аргаар эвдэрсэн 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ.

6.0. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨР

“МАНДАХ ДОРНЫН ЖОНШ” ХХК нь 2025 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Алтанширээ сумын засаг даргын 2025.05.20 өдрийн 01/187 тоот саналын дагуу хийж гүйцэтгэх. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 500 мод тарихаар төлөвлөв.

Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах ажил

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжи хнэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Алтанширээ сумын засаг даргын 2025.05.20 өдрийн 01/187 тоот саналын дагуу	га	-	-	2000000	2025 онд	
2	Төслийн талбайд нийт ашиглалтын хугацаанд 500 ш мод тарина.	га	500		2500000	ТЗ-ийн талбайд	
Нийт					4 500 000		

7.0. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

8.0. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“МАНДАХ ДОРНЫН ЖОНШ” ХХК-ийн “Өмнө бага чулуу” хайлуур жоншны ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Алтанширээ сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

9.0. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

10.0. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслоны хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Ахуйн хог Хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг сумын ТҮК-тэй гэрээ байгуулан зөөвөрлөх	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нэгдсэн хогийн цэгт хогоо нийлүүлэх	кг	-	-	Уурхайн дотоод зардалд орсон.	Хог хаягдлын тухай хууль
		Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна.	Ажилчдын байрны гадна болон босоо амны дэргэд байршуулах	тоо	100000	6	600000	
		Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Ахуйн хог хаягдал хадгалах хэсэгт	Га	500000	0.3	500000	
		Ахуйн хог хаягдлаа цэвэрлэх зорилгоор уурхай орчмын талбайд их цэвэрлэгээ хийж орчин тойрноо цэвэрлэнэ.	Уурхайн талбай орчим					
2	Үйлдвэрийн хог хаягдал	Уурхайд ашиглаж буй машинаас гарсан хаягдал тос, маслог зориулалтын цэгт хуримтлуулах, дугуй ламп гэх мэтийг дахивар авах газарт тушаана.	Уурхайд ашиглагдаж буй машин болон бусад зүйлс	тоо	300000	-	300000	
	Нийт						1400000	

11.0. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ

Аянга цахилгаан: Дулааны улиралд тохиолдох бөгөөд цаг агаарын мэдээг тогтмол мэдээлэх хэрэгтэй. Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, ил задгай цахилгааны утас зэрэг аянга үүсэж болзошгүй зүйлүүдийг хамгаалах

Газар хөдлөлт: Газар хөдлөлтийн мужлалаар төсөл хэрэгжих газар нь 6 баллын бүсэд хамаарна. Иймээс барилга байгууламж барихдаа зураг төслийн дагуу эрсдэлийг нарийвчлан авч үзэх шаардлагатай. Мөн ашиглалтын явцад газар хөдлөлтийн үед авах арга хэмжээг боловсруулах. Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бийболгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх.

Шороон шуурга: Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бийболгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх Халдварт өвчин: Уурхайн ажилчдад хууль бус ан агнахгүй байх түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөллийн талаар сургалт явуулах, хамгаалалтын хэрэгслээр хангах (амны хаалт г.м), аймгийн эрүүл мэндийн төвтэй харилцаа холбоотой байж мэдээлэл авч байх

Гал түймэр: Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслийн хангамж, цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах үд мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУ-н “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Аж ахуй нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”, “Гал түймрийн аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан тушаал, шийдвэрийн дагуу зохион явуулна

Авто тээврийн осол: Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчдын аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах. Уурхайн зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллах.

Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Үйлдвэрийн аваар осол, саатал гэмтлээс шалтгаалан ажилчид бэртэж гэмтэх, хөдөлмөрийн чадвараа алдах эрсдэлтэй,	Хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн зөвлөмжийг боловсруулж, ажилчдад сургалт явуулах.	Уурхайн ажилчид	-	-	100000	Жилд 1 удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
2	Ажлын байран дээрх осол эрсдэлээс сэргийлж ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах	Компани	-	-	1000000	2025 онд	
3	Ажлын байран дээрх осол эрсдэлээс сэргийлж хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслээр хангах		Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	-	Дотоод үйл ажиллагааны зардал	2025 онд	
4	Уурхайн эмнэлгийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Анхны түргэн тусламжийн багаж, эмээр хангах	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд	-	-	500000	2025 онд	
5	Анхны түргэн тусламжийн сургалтад хамруулах	Аливаа осол гэмтэлд өртсөн хүний биеийн байдлыг цаашид улам хүндрүүлэхгүй байх, нэмж гэмтэл авахаас хамгаалах, биеийн чухал эрхтний үйл	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд			Үйл ажиллагааны зардалд орсон	2025 онд 1 удаа	

Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших MV-021637 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Өмнө бага чулуу” хайлуур жоншны далд ордын 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

2025 он

		ажиллагааг сэргээх, хэвийн байдалд оруулахын тулд						
	Нийт					1600000		

12.0. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Мандах дорнын жонш” ХХК-ийн “Өмнө бага чулуу” хайлуур жоншны орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээний локаль мониторингийн систем байгуулах нь зүйтэй. Мониторингийн цэгийг зөв сонгож, хугацаа, давтамж зэргийг нь оновчтой сонгож өгөх нь чухал юм. Тус төслийн орчимд явуулбал зохих экологийн хяналтын мониторингийн ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, мониторингийн ажлын давтамж, хэмжилт судалгааны ажлыг хариуцах мэргэжилтэн, мониторингийн үзүүлэлт зэргийг доорх хүснэгтэд тусган оруулж өгөв.

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Агаар	уурхайн босоо гол ам, хотхон, засварын талбай, зам	6 болон 10-р сард	4 цэгт 1 удаа	100000 /Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори/	400000* 2	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2.	Хөрс	Уурхайн шимт хөрсний овоолго, хотхон, засварын талбай, эрүүл талбай,	6 болон 10-р сард	4 цэгт 1 удаа	Хөрсний хяналт шинжилгээний 4 цэгт жилд удаа Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 25000 төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 75.0 мян.төг <i>Инженер геодези хөрсний төв лаборатори</i>	300000 * 2	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
3.	Ус	Унд ахуйн ус,	6 болон 10-р сард	2цэгт 1 удаа	Бүрэн шинжилгээний үнэ 150000 төг	150000 * 2	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ,	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005,
	Нийт					1700000		

13.0. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажиллана.

Хүснэгт 9. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Усны нөөцийг үр ашигтай ашиглаагүйгээс газрын доорх усны нөөц, горимд өөрчлөлт орно.	Ус ашиглах дүгнэлт гаргуулан, холбогдох газраас ус ашиглах дүгнэлт гаргуулах	Төслийн талбайд	500000	2025 онд	Усны тухай хууль
Уурхайн зам талбайд осол аваараас сэргийлэх	Уурхайн зам талбайд осол аваараас сэргийлж тэмдэг тэмдэглэгээнүүдийг сайтар хийх		500000	2025 онд	
Уурхайн үер уснаас хамгаалах суваг шуудуу татах	Үерийн усны даланг сэргээх		500000	2025 онд	
Байгаль орчны аудитын тайлан хийлгэх	Байгаль орчны үйл ажиллагаа, БОННУ-ний хэрэгжилтийн нийцэл зэргийн үнэлж, зөвлөмж боловсруулах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгасан.	2025 онд	
Нийт			1500000		

14.0. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сум багын иргэдэд тайлагнах ажлын хуваарь

Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Сумын иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.		10-р сард	Дотоод үйл ажиллагааны зардалд	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.	-
2		Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.		11 сарын 1-нд багтаан			-
	Нийт	Дотоод үйл ажиллагааны зардалд орсон.					

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Хүснэгт 11. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	1750.0
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	2000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	2000.0
4	Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих	2500.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1400.0
6	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1600.0
8	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1700.0
10	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	1500.0
	2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	14450.0

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нөхөн сэргээх арга хэмжээнд нийт 14.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Үүний 50 хувь 7.225 сая төгрөг байна. Бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.